

БАЯНХОНГОР АЙМГИЙН “ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР”

Огноо: 2019.01.07

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВД ХҮҮХДИЙН ХҮНСНИЙ МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Гэрээний нэр, дугаар: Баянхонгор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд,
залуучуудын хөгжлийн төвд хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх:
БХАОНӨГ/201963

2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Баянхонгор аймгийн Оргон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баянхонгор аймгийн Хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх: БХАОНӨГ/201963-ыг** нийлүүлэх тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 / тавин мянган төгрөгийг/ цахим систем ашиглан төлсөн байх ёстай.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [**2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 10 цаг**]-аас өмнө өөрийн аж ахуй нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор www.tender.gov.mn сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлуулан тендерийг [**2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн [10 цаг 10 минут]**]-д аймгийн Орон нутгийн өмчийн газрын 115 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**[Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар
(нэг давхар, 114 тоот өрөөнөөс авах буюу 70443224 утсаар холбогдоно.)**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| <p>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</p> <p>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</p> <p>3. Тендерийн иж бүрдэл</p> <p>4. Тогтмол үнэ</p> <p>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</p> <p>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</p> <p>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</p> <p>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</p> | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p> <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">(а) Үнийн санал;(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;(г) Тусгай зөвшөөрөл шаардлаггүй;(д) Бэлтгэж ирүүлэх ТШӨХ-д заасан бусад материал: <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илрэхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p> <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p> <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p> <p>7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.</p> <p>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.</p> <p>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.</p> <p>8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.</p> |
|---|--|

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

**ТОӨЗ-НЫ
ХОЛБОГДОХ
ЗААЛТ**

Шалгуур үзүүлэлт

ТОӨЗ 1.1

Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:

1. Энэхүү тендерийн бичиг баримтад тусгагдсан жишиг маягтын дагуу багц тус бүрээр гаргаж баталгаажуулсан үнийн санал ирүүлэх
2. Нийлүүлэлтийн баталгаажуулсан график ирүүлэх
3. Улсын бүртгэлийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулсан хуулбар /Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хүнсний дэлгүүрийн худалдаа эрхэлдэг байх/
4. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх банкнаас ирүүлэх
5. Харилцагч Татварын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагaa тодорхойлолтыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance-aас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/
6. Шүүхийн байгууллагаас сүүлийн 3 жилтэй холбогдох тодорхойлолт ирүүлэх.
7. Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх. /Хугацаа тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байх/
8. Харилцагч Нийгмийн даатгалын байгууллагаас өр төлбөргүй тухай лавлагaa тодорхойлолт ирүүлэх. /Тендер нээсэн өдрийн байдлаар өргүй байх/
9. Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: /2016,2017/ оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хуулбарыг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance-aас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.

	<p>10. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил /2017, 2018/ гэрээг хавсарган ирүүлэх.</p> <p>11. Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Шаардлагатай. Гэрээт хугацаанд нийлүүлэгдэх бүх бараа нь эрүүл ахуйн ахуйн стандарт шаардлага хангасан зориулалтын сав, баглаа боодолтой, МХГ болон бусад холбогдох газрын шинжилгээний бичиг, тээвэрлэлтийн үеийн гэмтлийг буцаах, солиулах, хугацаа хэтэрсэн тохиолдолд буцаах зэрэг тодорхойлолтыг албан бичгээр ирүүлэх.</p> <p>12. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жил /2016, 2017/ Сүүлийн 2 жил /2016, 2017/ оны борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн дундаж нь санал болгож үнийн дүнгийн 80 хувиас багагүй байх байна.</p> <p>13. Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: Сүүлийн 2 жил Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй хэмжээний ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа гүйцэтгэсэн байна. Гэрээг хавсарган ирүүлнэ. /Ижил төстэй ажил гэдэгт гэрээгээр хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж байсан туршлагыг тооцно./</p> <p>14. Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: Гэрээг хэрэгжүүлэх ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, агуулах склад, тээврийн хэрэгсэл зэргийг өөрийн болон түрээсээр эзэмшигч тухайгаа нотлох баримтаар ирүүлэх.</p> <p>15. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 50%-иас багагүй байх.</p> <p>16. Тухайн тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримт, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, агуулах гэх мэт барааг бүтэн жилийн хугацаанд тасралтгүй, гэрээний дагуу нийлүүлэх боломжтойг нотлох баримт фото зураг зэрэг холбогдох мэдээллийн хамт тусгайлан бэлтгэж ирүүлэх.</p> <p>17. Гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Удирдах болон голлох ажилтнуудын сургууль төгссөн диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбар,</p>
--	--

	<p>нийгмийн даатгалын дэвтэрийн хуулбар арын тушаалын хэсгийг оруулсан байх мөн Байгууллагын 2018 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын НД-7,8 маягтыг хавсарган ирүүлнэ.</p> <p>18. 2018 онд хийсэн ижил төстэй ажлын гэрээний хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагаас тодорхойлолт авч ирүүлэх.</p> <p>19. Тендерт шалгарсан тохиолдолд нийлүүлэгч нь өөрийн зардлаар барааг хүлээн авах газарт хүлээлгэн өгөхөө албан бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>20. <i>Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал, банк, бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, ял шийтгэлтэй болох нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</i></p> <p>21. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана.</p> <p>22. ТШӨХ-д заасан материалыудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>23. Тендерт оролцогч аж ахуй нэгж нь тендерийн баримт бичгийн дагуу материалыа эмх цэгтэй, харагдахуйц тод бэлтгэж ирүүлнэ. /Ирүүлсэн материалын харагдах байдал хангалтгүй тохиолдолд тухайн материалыг хангалтгүйд тооцож үнэлгээнд харгалзахгүй/</p> <p>Санхүүжилтийн эх үүсвэр нь: Улсын төсвийн хөрөнгөөр</p>
--	--

ТОӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Тендер хүлээж авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалыа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.] Огноо: 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн Цаг: 10 цаг 00 минут
ТОӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Давхар болон өрөөний дугаар: [Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар (нэг давхар 115 тоот өрөө)] Огноо: 2019 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн Цаг: [10 цаг 10 минут]
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь [дараах багц-3]-ээс бурдэнэ:

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД,
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВД ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ
НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫГ
ОРУУЛАВ.**

1-р багц Гурил гурилан бүтээгдэхүүн

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Бараа бүтээгдэхүүний гарал үсэл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Дээд гурил	Алтан тариа түүнтэй дүйцэхүйц	кг	476,8038	1200	619846
2	1-р гурил	Алтан тариа түүнтэй дүйцэхүйц	кг	410,85	1200	493020
3	Цагаан будаа	Орос түүнтэй дүйцэхүйц	кг	112	2400	268800
4	Шар будаа	Орос түүнтэй дүйцэхүйц	кг	100	3500	350000
5	Хөц будаа	Орос түүнтэй дүйцэхүйц	кг	40	1700	68000
6	Бор гоймон	Орос түүнтэй дүйцэхүйц	ш	40	1600	64000
7	Элсэн чихэр	Орос түүнтэй дүйцэхүйц	кг	100	200	200000
8	Хүүхдийн будаа	Орос түүнтэй дүйцэхүйц	ш	50	1700	85000
9	Ургамлын тос	Орос түүнтэй дүйцэхүйц	кг	50	4600	230000
10	Масло	Орос түүнтэй дүйцэхүйц	кг	90	3500	315000
11	Давс	Иоджуулсан Монгол түүнтэй дүйцэхүйц	кг	17,934	1000	17934

12	Цайны идээ	Их тайгатай дүйцэхүйц	Ш	20	5950	119000
13	Хөөлгөгч	Англи түүнтэй дүйцэхүйц	Кг	5	5400	27000
14	Сода	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	10	1200	12000
15	Огурцы	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	30	4500	135000
16	Лаврын навч	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	5	1800	9000
17	Пүнтүүз	Солонгос түүнтэй дүйцэхүйц	Кг	20	1600	32000
18	Үзэм	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	50	7500	375000
19	Хар чавга	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	25	15000	375000
20	Майонез	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	4,5	5600	25200
21	Өндөг	Монгол түүнтэй дүйцэхүйц	Ш	90	400	36000
22	Вандуй	Орос түүнтэй дүйцэхүйц	Ш	10	1500	15000
23	Далайн байцаа	Солонгос түүнтэй дүйцэхүйц	Ш	25	2600	65000
24	Арвайн гурил	Монгол түүнтэй дүйцэхүйц	Кг	5	2500	12500
25	Төрөл бүрийн печень	Орос түүнтэй дүйцэхүйц	Ш	40	4700	188000
26	Вафль печень	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	40	6800	272000
27	Амтат чинжүү	Монгол түүнтэй дүйцэхүйц	Кг	20	4000	80000
28	Сармис	Монгол түүнтэй дүйцэхүйц	Кг	10	500	5000
29	Чацаргана	Монгол түүнтэй дүйцэхүйц	Кг	90	5000	450000
30	Чихэр	Монгол түүнтэй дүйцэхүйц	Кг	40	8500	340000
31	Алим	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	40	3900	156000
32	Чангаанз	Орос түүнтэй дүйцэхүйц	Кг	30	8500	255000
33	Алимны шүүс	Орос түүнтэй дүйцэхүйц	Л	25	5000	125000
34	Нэрсний шүүс	Монгол түүнтэй дүйцэхүйц	Л	25	5000	125000
						5820300

2-р багц Хүнсний ногоо

1	Төмс	Монгол түүнтэй дүйцэхүйц	кг	1000	1000	1000000
2	Байцаа	Монгол түүнтэй дүйцэхүйц	кг	100	1600	160000
3	Лууван	Монгол түүнтэй дүйцэхүйц	кг	120	1800	216000
4	Манжин	Монгол түүнтэй дүйцэхүйц	кг	60	1400	84000
5	Сонгино	Монгол түүнтэй дүйцэхүйц	кг	30	1900	57000
						1517000

3-р багц Сүү, мах махан бүтээгдэхүүн /Гарал үүслийн бичиг чанарын шинжилгээний бичигтэй/

1	Хонины мах	Тарган 1-р зэргийн мах	Кг	900	5000	4500000
2	Үхрийн мах	Тарган 1-р зэргийн мах	Кг	764	5000	3820000
3	Шингэн сүү	Сүүний чиглэлийн үхрийн сүү	Кг	891,9	3000	2675700
4	Аарц	Үхрийн шар сүүгүй аарц	Кг	50	4500	225000
5	Ааруул	Хангайн ааруул	кг	30	15000	450000
						11670700

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг **[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу **[тоо]** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн
1	2	3	4	5	6
Тендерийн нийт үнэ					

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаар хүлээн авч байгаа гэрээний хувьд хамарагчийг.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [0] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [14] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| <p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p> <p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p> <p>3. Баталгаат засвар (ГЕН-5)</p> <p>4. Төлбөр (ГЕН – 7)</p> <p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)²</p> | <p>1.1. Нийлүүлэгдэх барааг холбогдох ажилтан зарлагын баримт нэхэмжлэх, санхүүгийн баримтаар хүлээн авч баталгаажуулна.</p> <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо хэмжээ, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
4) барааны гарал үүслийн гэрчилгээ.</p> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээний үнийн дүнгийн [100]¹ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p> <p>9.1. Алданги оногдуулах хувь: [0.5 хувь]
Алдангийн нийт дүн: [10 хувь]</p> |
|--|--|

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]